

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Shinjlenmagadlahui.ezshaudit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 15 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ш.ЯДАМСҮРЭН
ТАНАА

2025.02.25 № 120

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 83.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 2 хувийг байр ашиглалтай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020240

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус сургуулийн цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 985,118,1 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 28,8 хувиар өссөн байна.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр дөрөв дүгээр түвшинд үнэлэгдэж, урамшууллын санхүүжилт аваагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургууль нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт 50 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 99,1%-ийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



9022899
4517143826

Ш.МӨНХБАЯР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А
/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>464,319,380.59</u>	<u>611,058,564.72</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	391,619,831.68	507,915,196.01
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	391,619,831.68	507,915,196.01
3121	Төгрөг	391,619,831.68	507,915,196.01
31211	Төрийн сангийн харилцах	391,619,831.68	507,915,196.01
35	БАРАА МАТЕРИАЛ	72,699,548.91	103,143,368.71
354	Хангамжийн материал	72,699,548.91	103,143,368.71
35410	Бичиг хэргийн материал	-	159,000.00
35420	Аж ахуйн материал	1,622,920.00	1,412,920.00
35470	Бусад хангамжийн материал	71,076,628.91	101,571,448.71
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,902,650,361.68</u>	<u>3,792,294,126.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,902,650,361.68	3,792,294,126.54
392	Биет хөрөнгө	3,315,600,361.48	3,206,444,126.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,901,548,776.00	2,901,548,776.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(420,939,321.75)	(504,590,281.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	723,164,133.71	793,825,333.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	(209,023,313.26)	320,082,741.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	272,725,922.69	307,973,751.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(93,244,820.99)	(112,587,559.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,567,191.25	42,567,191.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,230,434.40)	(23,330,241.52)
39217	Ном	120,032,228.23	121,119,898.19
393	Биет бус хөрөнгө	587,050,000.20	587,050,000.20
39301	Програм хангамж	13,743,936.00	13,743,936.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,743,935.80)	(9,943,936.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	582,050,000.00	582,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,366,969,742.27</u>	<u>4,403,352,691.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,366,969,742.27</u>	<u>4,403,352,691.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,366,969,742.27	4,403,352,691.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,251,190,746.70	1,251,190,746.70
512	Хуримтлагдсан үр дүн	(113,461,494.53)	(77,078,545.54)
51210	Өмнөх үеийн үр дүн	(570,775,319.29)	(113,461,494.53)
51220	Тайлант үеийн үр дүн	457,313,824.76	36,382,948.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,229,240,490.10	3,229,240,490.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,366,969,742.27</u>	<u>4,403,352,691.26</u>

ХТ05430 @ 9822899

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,716,006,438.48	4,265,271,065.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	488,820,538.48	82,221,965.00
120	Нийтлэг татварын бус орлого	488,820,538.48	82,221,965.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	488,820,538.48	82,221,965.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,460,900.00	21,250,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,082,880.00	10,210,370.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	450,276,758.48	50,761,595.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,227,185,900.00	4,183,49,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,158,185,900.00	4,079,584,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,158,185,900.00	4,079,584,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,000,000.00	93,464,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,000,000.00	93,464,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,228,102,469.83	4,222,295,785.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,228,102,469.83	4,222,295,785.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,019,182,337.80	4,004,300,483.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,231,441,649.00	3,033,026,418.00
210101	Үндсэн цалин	1,511,228,494.00	2,022,172,069.00
210102	Нэмэгдэл	657,631,936.00	906,806,849.00
210104	Урамшуулал	62,581,219.00	104,047,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,025,160.00	377,133,378.12
210201	Тэтгэврийн даатгал	188,860,758.00	257,594,570.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,791,199.00	30,276,077.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,432,981.00	15,145,702.12
210204	Ажилгүйдлийн даатгал	4,358,221.00	14,811,651.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,582,001.00	59,305,378.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,458,747.97	84,332,033.06
210301	Гэрэл, цахилгаан	17,203,877.92	21,486,964.82
210302	Түлш, халаалт	34,119,357.11	33,125,178.57
210303	Цэвэр, бохир ус	13,135,512.94	29,719,889.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,564,233.00	13,499,934.00
210604	Урсгал засвар	103,564,233.00	13,499,934.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,014,284.00	95,762,883.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,799,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,214,384.00	95,762,883.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	311,678,263.83	400,545,836.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,931,821.32	84,933,756.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,534,667.79	61,745,930.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	205,211,774.72	253,866,150.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,920,132.03	217,995,302.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	208,296,000.00	212,152,500.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	208,296,000.00	212,152,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	624,132.03	5,842,802.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	624,132.03	5,842,802.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>487,903,968.65</u>	<u>42,975,279.03</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	<u>30,590,143.89</u>	<u>6,592,330.04</u>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	30,590,143.89	6,592,330.04
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	<u>(30,590,143.89)</u>	<u>(6,592,330.04)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>457,313,824.76</u>	<u>36,382,948.99</u>




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,265,729,680.00</u>	<u>4,214,509,470.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,543,780.00	31,460,370.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,543,780.00	31,470,370.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,543,780.00	31,470,370.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,460,900.00	21,250,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,082,880.00	10,210,370.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,227,185,900.00	4,173,49,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,158,185,900.00	4,079,584,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,158,185,900.00	4,079,584,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,000,000.00	93,464,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,000,000.00	93,464,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,912,253,204.32</u>	<u>3,950,598,205.67</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,912,253,204.32	3,950,598,205.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,703,333,072.29	3,732,602,902.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,231,441,649.00	3,033,026,418.00
210101	Үндсэн цалин	1,511,228,494.00	2,022,172,069.00
210102	Нэмэгдэл	657,631,936.00	906,806,849.00
210104	Урамшуулал	62,581,219.00	104,047,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	276,025,160.00	377,133,378.12
210201	Тэтгэврийн даатгал	188,860,758.00	257,594,570.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,791,199.00	30,276,077.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,432,981.00	15,145,702.12
210204	Ажилгүйдлийн даатгал	4,358,221.00	14,811,651.00
210205	Эрүүл мэндийн даатгал	43,582,001.00	59,305,378.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,458,747.97	84,332,033.06
210301	Гэрэл, цахилгаан	17,256,534.92	21,486,964.82
210302	Түлш, халаалт	34,119,357.11	33,125,178.57
210303	Цэвэр, бохир ус	13,082,855.94	29,719,889.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	13,499,934.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	13,499,934.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,014,284.00	95,762,833.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,799,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,214,384.00	95,762,833.55
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,393,231.32	128,848,256.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,461,731.32	90,068,156.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,931,500.00	38,780,100.00


213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,920,132.03	217,995,302.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	208,296,000.00	212,152,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	208,296,000.00	212,152,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	624,132.03	5,842,802.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	624,132.03	5,842,802.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>353,476,475.68</u>	<u>263,911,264.33</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	115,107,939.00	147,615,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	115,107,939.00	147,615,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	115,107,939.00	147,615,900.00
222001	Тоног төхөөрөмж	106,720,939.00	91,099,600.00
223001	Бусад хөрөнгө	8,387,000.00	56,516,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(115,107,939.00)</u>	<u>(147,615,900.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	238,368,536.68	116,295,364.33
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	153,251,295.00	391,619,831.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	391,619,831.68	507,915,196.01



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,251,190,746.70	3,299,240,490.10	(570,775,319.29)	3,909,655,917.51
Тайлант үеийн үр дүн	-	-	457,313,824.76	457,313,824.76
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,251,190,746.70	3,299,240,490.10	(113,461,494.53)	4,366,969,742.27
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,251,190,746.70	3,299,240,490.10	(113,461,494.53)	4,366,969,742.27
Тайлант үеийн үр дүн	-	-	36,382,948.99	36,382,948.99
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,251,190,746.70	3,299,240,490.10	(77,078,545.54)	4,403,352,691.26



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,626,885,100.00	4,092,371,302.73	(534,513,797.27)	88.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,626,885,100.00	4,092,371,302.73	(534,513,797.27)	88.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,390,142,600.00	3,880,218,802.73	(509,923,797.27)	88.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,419,848,900.00	3,033,026,418.00	(386,822,482.00)	88.69
210101	Үндсэн цалин	2,354,953,400.00	2,022,172,069.00	(332,781,331.00)	85.87
210102	Нэмэгдэл	982,875,600.00	906,806,849.00	(76,068,751.00)	92.26
210104	Урамшуулал	82,019,900.00	104,047,500.00	22,027,600.00	126.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	427,481,300.00	377,133,378.12	(50,347,921.88)	88.22
210201	Тэтгэврийн даатгал	290,687,200.00	257,594,570.00	(33,092,630.00)	88.62
210202	Тэтгэмжийн даатгал	34,198,500.00	30,276,077.00	(3,922,423.00)	88.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,099,300.00	15,145,702.12	(1,953,597.88)	88.57
210204	Ажилгүйдлийн даатгал	17,099,300.00	14,811,651.00	(2,287,649.00)	86.62
210205	Эрүүл мэндийн даатгал	68,397,000.00	59,305,378.00	(9,091,622.00)	86.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,825,400.00	84,332,033.06	(30,493,366.94)	73.44
210301	Гэрэл, цахилгаан	18,204,400.00	21,486,964.82	3,282,564.82	118.03
210302	Түлш, халаалт	72,121,000.00	33,125,178.57	(38,995,821.43)	45.93
210303	Цэвэр, бохир ус	24,500,000.00	29,719,889.67	5,219,889.67	121.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,172,000.00	29,835,834.00	(336,166.00)	98.89
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	5,899,600.00	(100,400.00)	98.33
210602	Тавилга	10,672,000.00	10,436,300.00	(235,700.00)	97.79
210604	Урсгал засвар	13,500,00.00	13,499,934.00	(66.00)	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,827,300.00	95,762,883.55	(4,064,416.45)	95.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,827,300.00	95,762,883.55	(4,064,416.45)	95.93
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,827,300.00	95,762,883.55	(4,064,416.45)	95.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,987,700.00	260,128,256.00	(37,859,444.00)	87.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	256,917,200.00	219,057,756.00	(37,859,444.00)	85.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,070,500.00	41,070,500.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	236,742,500.00	212,152,500.00	(24,590,000.00)	89.61

2132	Бусад урсгал шилжүүлэг	236,742,500.00	212,152,500.00	(24,590,000.00)	89.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	236,742,500.00	212,152,500.00	(24,590,000.00)	89.61
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,626,885,100.00	4,208,666,667.06	(418,218,432.94)	90.96
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,079,584,700.00	4,089,584,700.00	10,000,000.00	100.25
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,079,584,700.00	4,079,584,700.00	-	100
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00	10,000,000.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	120,825,400.00	87,621,597.06	(33,203,802.94)	72.52
132001	Орон нутгийн төсвөөс	120,825,400.00	87,621,597.06	(33,203,802.94)	72.52
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	426,475,000.00	31,460,370.00	(395,014,630.00)	7.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,752,000.00	21,250,000.00	3,498,000.00	119.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,500,000.00	10,210,370.00	(7,289,630.00)	58.34
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	391,223,000.00	-	(391,223,000.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	391,619,831.68	391,619,831.68	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	507,915,196.01	507,915,196.01	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
3	Төсвийн байгууллага	1	1	-	100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	119	119	-	100
6	Удирдах ажилтан	1	1	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	103	103	-	100
8	Үйлчлэх ажилтан	15	15	-	100
11	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	2,146.00	2,134.00	(12)	99.44



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургууль “Суралцагчдын ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, ахиц гаргана” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт /үнэлгээний шалгуур, сургалтын чанар/
- Багшийн хөгжлийг дэмжих
- Сургалтын орчинг сайжруулж, материаллаг баазыг нэмэгдүүлэх
- Сургуулийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгох
- Сургуулийн гадаад дотоод хамтын ажиллагаа
- Суралцагчдын хөгжил, хамгаалал
- Удирдлагын манлайлал
- Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд олгох

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Монгол улсын засгийн газрын Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 488 дугаар тогтоол хэрэгжсэн,
- Монгол улсын засгийн газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай 2022 оны 491 дүгээр тогтоол мөрдөгдөж эхэлсэн,
- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 10 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэн, ,
- 2023 оны 8 дугаар сарын 6-ний өдрөөс Боловсролын ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэн.
- Монгол улсын засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолыг мөрдөж эхэлсэн,

- Монгол улсын засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолыг мөрдөж эхэлсэн байна.
- Монгол улсын сангийн сайдын 2024 оны “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай ” А/52 тоот тушаалыг хэрэгжүүлэн эхлэсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн бэлтгэсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,382.9 мянган төгрөгөөр буюу 2,8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	391,619.8	507,915.2	116,295.4
Бараа материал	72,699.5	103,143.4	30,443.9
Үндсэн хөрөнгө	3,902,650.4	3,792,294.1	(110,356.3)
Нийт хөрөнгө	4,366,969.7	4,403,352.7	36,383.0

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,251,190.7	1,251,190.7	-
Хуримтлагдсан үр дүн	(113,461.50)	(77,078.5)	(36.383.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,229,240.50	3,229,240.50	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,366,969.7	4,403,352.7	36,383.0

Тайлант жилийн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 507,915.2 мянган төгрөгийг Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 507,915.2 мянган төгрөг болж 116,295.4 мянган төгрөгөөр өссөн нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэлийг зарцуулаагүйтэй холбоотой. Мөн Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сараас цалин хөлс 6 хувиар нэмэх шийдвэрээр төсөв нэмж өгснөөс шалтгаалсан байна.

Дархан-уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургууль нь 2024 оны 12 дугаар сарын 31 өдрийн байдлаар өр, авлага гаргаагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эцэст 103,143.4 мянган төгрөг болж өссөн нь төсвийн хөрөнгөөр 89,303.3 мянган төгрөгийн барааг худалдан авч, 107,134.7 төгрөгний зарлага гарч, мөн 48,275.3 мянган төгрөгийн пийрсэн англи хэлийн хөтөлбөрийн хүрээнд Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар англи хэлний сурах бичиг нийлүүлсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,792,294.1 мянган төгрөг болж 30,443.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 94,935.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж 47,486.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 7,680.0 мянган төгрөгийн номын фондны ном сурах бичиг худалдан авсан, мөн 2,486.3 мянган төгрөг цахим ангийн тоног төхөөрөмж буюу зурагтыг боловсрол ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар ирснийг тус тус орлого авч данс бүртгэлд тусгаж нэмэгдсэн байна. Мөн Дархан-уул аймгийн засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 43,105.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,800,300.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 113,410.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Энэ нь 2024 оны төсвийн төслийг бодитой нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлаар тооцож үндэслэлтэй боловсруулсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг оны сүүлд 148,041.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж санхүүжүүлсэн байна. Мөн нөхөн ханалтын зардал дээр цахим ангийн

сурагч ширээ сандлын санхүүжилт 25,000.0 сая төгрөгний төсөв нэмж өгсөн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,079,584.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 120,825.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 25,252.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төсөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургууль нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,089,584.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 87,621.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 31,460.4 мянган төгрөгт төвлөрч, орон нутгийн төсвөөс зарцуулаагүй үлдэгдэл 5,842.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,092,371.3 мянган төгрөг буюу 88.7 хувьтай байгаа нь цалинтай холбоотой зардлаас 442,540.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлаас 5,842.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлаас 40,784.4 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрөөс 24,590.0 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	10,267.7	10,262.1	5.6	99.9	
2	80312- Сургалт семинар	10,192.4	6,569.0	3,623.4	64.0	
3	80233- Хүүхэд хамгаалал	7,032.3	6,845.1	187.20	97.3	
4	81605- Эрүүл мэндийг дэмжих	19,496.9	4,559.0	14,937.	23.4	
5	81801- Үдийн цай хөтөлбөр	236,742.5	212,152.5	24,590.0	89.6	
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	111,585.7	111,585.0	0.7	100.0	
7	81823- Боловсролын багшийн сургалт	30,915.5	16,332.7	14,582.8	52.8	
8	81834- Боловсролын стандарт сургалт	3,929,969.1	3,487,825.1	442,540.8	88.7	
9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	88,018.4	88,018.4	-	100.0	
10	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	19,152.1	18,810.9	3,839.2	83.0	
11	81875-	25,187.1	21,579.6	3,607.5	85.7	
12	83603- Дээд шатны төсвөөс хуваарилсан	10,000.0	10,000.0	-	100.0	
13	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	128,325.4	97,831.9	5,842.8	94.4	
		4,626,885.1	4,092,371.2	507,915.2	88.7	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус сургууль нь 2024 оны батлагдсан 119 багш ажилчидын орон тоо батлаж өгснөөс захиргаа аж ахуйн 28 ажилласад, бага ангийн 23 багш дунд, ахлах ангийн 68 багш нийт 119 багш ажилчидтай ажилласан байна. Худалдан авах ажиллганы долоон нэр төрлийн 381,159.5 мянган төгрөгний төлөвлөгөө гарган tender.gov.mn байршуулан “Үдийн хоол” хөтөлбөрийн хүрээнд 216,877.5 мянган төгрөг, англи хэлний “ТИЙРСЭН” хөтөлбөрийн хүрээнд 35,769.7 мянган төгрөгний нээлтэй

тендер зарлаж шалгаруулан худалдан авалт хийж ажилласан байна. Худалдан авах үйл ажиллагааны зардлын эдийн засгийн ангилаар авч үзвэл 210801 зардлаас бараа ,үйлчилгээний зардал гаргаагүй, харин 210901 зардлаас гэрээ байгуулан 219,057.7 мянган төргөний бараа үйлчилгээг худалдан авалт хийсэн байна.

2024 оны Ахмадын сан байгуулаагүй хөрөнгө мөнгө гараагүй байна:

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд тус байгууллага дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтын хэлтсээс 111,585,7 мянган төгрөгийн өртөгтэй цахим анги, англи хэлний пэйрсэн хөтөлбөрийн хүрээнд хичээлийн цахим кабинетыг бүрэн тохижуулж өрөөний дотоод засал, тоног төхөөрөмж, сурагч ширээ сандал буюу тавилга эд хогшлыг нөхөн хангалтын зардлаар бий болгосон байна. Мөн хандиваар англи хэлний пэйрсэн хөтөлбөрийн хүрээнд 48,275.3 мянган төгрөгийн англи сурах бичгийг хөрөнгө оруулалтаар хийсэн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Цахим кабинет	2024 он	Сургалтын үр дүнг сайжруулах	100%	111,585.7	111,585.0
Дүн					111,585.7	111,585.0

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл бичих

Тус байгууллага нь 2024 онд үдийн хоол хөтөлбөр дээр 216,877.5 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт явуулж, нэг оролцогч оролцон “Баджижи” ХХК шалгарч гэрээ байгуулсан байна. Тайлант онд үдийн цай хөтөлбөрийн гүйцэтгэл 212,12.5 мянган төгрөг байна. Мөн англи хэлний пийрсэн хөтөлбөрийн сурагчдын сургалтын зардал 35,769.7 мянган төгрөгийн нээлттэй тендер зарлаж, нэг оролцогч оролцон “АЙ И ДИ СИ” ХХК шалгарч гэрээ байгуулсан байна. Тайлант онд англи хэлний пийрсэн хөтөлбөрийн суралцагсдын зардал гүйцэтгэл 35,769.7 мянган төгрөг гарсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ” аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 3,228,102.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 64,562.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургууль нь ашиглалтын зардлын хэрэглээг хянаж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалинтай холбоотой зардлаас 386,822.5 мянган төгрөг, үдийн хоол хөтөлбөрөөс 24,590.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 37,859.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 30,493.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгон ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн 15 дугаар сургууль нь 2024 онд мэдээлбэл зохих 169 мэдээллийн хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 66,127.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 4 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100.0 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	66,127.5	4	66,127.5	100
Нийт дүн	4	66,127.5	4	66,127.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс цалин хөлсний хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарсантай холбоотой цалин болон бараа үйлчилгээний бусад зардал дээр төсөв нэмж өгснөөс шалтгаалан 2024 оны 12 дугаар сарын 28-нд 118,683.3 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 73,562.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 8,042.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 61,879.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж 3,640.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 2 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

1. Сургуулийн захирлын 2024.01.02-ны А/09 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл", "Дотоод хяналтын ажилтан" томилж, зөвлөлийн гишүүдэд нийт 6,995.5 мянган төгрөг, дотоод хяналтын ажилтанд 1,047.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.6.2, 16 дугаар зүйлийн 16.5.9, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Боловсрол Шинжлэх Ухааны сайдын тушаалаар тоног төхөөрөмж авах нөхөн хангалтын зардлаас тавилга эд хогшил худалдан авсан 38,400.0 мянган төгрөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", БШУС-ын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 1а/1838 тоот албан бичигт "2024 оны нөхөн хангалтын зардлын төсвийн хуваарилалтыг сургууль, цэцэрлэг бүрээр хуваарилан 2024.04.18-ны өдрийн А/181 тоот тушаалаар баталсан заалттай нийцэхгүй байна.
2. Өндөр настны тэтгэвэр тогтоолгосон одоо ажиллаж байгаа 7 багш, 1 үйлчлэгч, 1 сантехникийн ажилчин албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл хөлс 23,479.6 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5 дах заалт, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, Захирлын 2024.09.02-ны өдрийн Хөдөлмөрийн гэрээ № 1-9 тоот, Төрийн албаны зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн 07 тоот зөвлөмжийн 8 дугаар заалтыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

5.3.1.1 Илрүүлэлт:

Сургуулийн захирлын 2024.12.13-ны А/90 дугаар тушаалаар байгууллагын хөдөлмөрийн аварга багш, бүтээлч багш, ингераци багш, шилдэг бага, дунд ангийн багш, судлаач бага багш нарт олгосон 3,640,000.0 төгрөгийн шагналыг цалингийн зардлаас зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, Сангийн сайдын А/3 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", байгууллагын 2024 оны батлагдсан төсөвт нийцэхгүй байна.

5.3.1.2 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардал хооронд гүйлгэсэн	1	3,640.0	-	-	-	-	1	3,640.0	-	-	-	-
Зөвлөлийн гишүүдэд нэмэгдэл хөлс олгосон	1	8,042.5	1	8,042.5	-	-	-	-	-	-	-	-
Нөхөн хангалтын зардлаас тавилга эд хогшил худалдан авсан	1	38,400.0			1	38,400.0			-	-	-	-
Өндөр настны тэтгэвэр тогтоолгосон ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл хөлс олгосон	1	23,479.6	1			23,479.6						
Дүн	4	73,562.1	2	8,042.5	1	61879.6	1	3,640.0				

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна.	1							1	
Дүн	1							1	

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 01/11-25720082-ДТТ-0005/07/11-СТТ-7113 Дархан сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сургуулийн захирлын 2024 оны А/09 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл" байгуулж гишүүдэд нийт 6,995,480 төгрөг, дотоод хяналтын ажилтан томилж 1,047,017.00 төгрөг, нийт 8,042,497.00 төгрөг цалингийн сангаас зарцуулж, төсвийн арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.6.2-т "Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Хөдөлмөрийн сайдын 2015 оны "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай" А/114 дүгээр тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д "Цалин хөлс, цагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үндэслэлгүй олгосон 8,042,497.00 (найман сая дөчин хоёр мянга дөрвөн зуун ерэн долоон) төгрөгийг Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн захирал Ш.Ядамсүрэн, нягтлан бодогч Д.Чинбат нараар төлүүлж, Төрийн сан банкин дахь Да.Хүү торгуулийн орлогын 100190000938 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар сургуулийн захирал Ш.Ядамсүрэн, нягтлан бодогч Д.Чинбат нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

"ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ
АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

С.ОРГИЛ

Л.МАГСАРЖАЛАМ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ш.МӨНХБАЯР



452050090



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 он 02 сар 25 өдөр

Дугаар 02/70-257002-2025/107/110-01-ТУС Дархан сум

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймаг Дархан сумын 15 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, одоо ажиллаж байгаа 9 албан хаагчид нийт 23,479,598.00 төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл хөлс олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 тоот зөвлөмжийн 8 дугаар заалтад "... Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно", сургуулийн захиралтай 2024 онд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж, нэмэгдэл цалин давхардуулан олгох зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дархан сумын 15 дугаар сургуулийн захирал Ш.Ядамсүрэн, нягтлан бодогч Д.Чинбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

"ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ ЭЗШ
АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

С.ОРГИЛ

Л.МАГСАРЖАЛАМ

Ш.МӨНХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:



4525040189